

Эрүүл мэнд спортын
сайдын 2016 оны 2 сарын
23 өдрийн 52 дугаар
тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн
шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад өгөх
ЗӨВЛӨМЖ
(Маягт №3)

2025 оны 04 сарын 01-ны өдөр

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СЭМТ-Д

№	Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт	Шалгуур үзүүлэлтийн дугаар	Зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам
БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ДЭД БҮЛЭГ 1: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ				
1	Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлыг хангах заавартай, мөрддөг байх	5.1	Мэс ажилбар хийх заавартай, ажилбар хийх бэлэн байдлыг хангах	- Мэс ажилбар хийх заавар боловсруулан батлах - Мэс ажилбар хийх иж бүрдлийн бэлэн байдлыг хангах - Өдөр тумын хяналт хийж, нөхөн хангалтыг хийдэг байх
ДЭД БҮЛЭГ 2. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ				
2	Тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн зааварт үндэслэн үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх шалгуурыг баталсан, мөрддөг байх	3.2	“Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS5081:2013 стандартын 8.3.1 заалтыг мөрдөх	- Тусламж үйлчилгээний стандарт, удирдамж, зааврыг үндэслэн хэвтүүлэн эмчлэх шалгуур, өвчин эмгэгийн жагсаалт гарган, СЭМТ-ийн даргаар батлуулах - Шалгуурын дагуу хэвтүүлдэг, бүртгэл хөтөлдөг байх
ДЭД БҮЛЭГ 3: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ МЭДЭЭЛЭЛЭЭР ХАНГАХ				
3	Цаг товлох үйлчилгээ үзүүлдэг байх	1.3	ЭМС-ын 2020 оны А/478 дугаар тушаал “Эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн цаг товлох үйлчилгээг утсаар зохицуулах журам”-г хэрэгжүүлэн ажиллах	- Байгууллагын хүрээнд мөрдөх оношилгоо, давтан үзлэг болон хэвтэн эмчлүүлэх зэрэг үйлчилгээний цаг товлох, чиглүүлэх үйл ажиллагааны заавар боловсруулж, СЭМТ-ийн даргаар батлуулан мөрдөх - Цаг товлох үйлчилгээ хариуцсан ажилтныг томилон ажиллуулах
4	Үйлчлүүлэгийн нууцыг хадгалдаг байх	5.1	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.9.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах	- Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах журмыг гаргах - Байгууллагын цахим мэдээллийн нууцыг хадгалах талаар зохицуулсан журмыг гаргах - Журмыг хэрэгжүүлж, баримт бичгийн нууцлалыг хадгалах нөхцөлийг бүрдүүлэх
ДЭД БҮЛЭГ 5. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ				

5	Халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийдэг байх	1.2	“Заавар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх, Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаанд тавих хяналт, үнэлгээг сайжруулах	- Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хийх хяналт, үнэлгээг эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, тусгаарлан сэргийлэлт, халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдал, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа, эмнэлгийн орчны цэвэрлэгээ, үйлчилгээ, хог хаягдлын менежментэд тус тус хийж, үнэлгээний дүнг ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад ашиглах - Гадаргуун халдваргүйтгэлийг хэвшүүлж, тарилгын аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтаны халдварт өртөх эрсдэлт хүчин зүйл, ЭМБ-ын аюултай хог хаягдлын ангилан ялгалт, эмнэлгийн орчны эрүүл ахуйн шаардлага, агаар солилцооны дэглэмийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлэн, дотоодын хяналт, үнэлгээг тодорхой давтамжтайгаар хийж судалгаа, дүгнэлттэй ажиллах
6	Үйлчлүүлэгчид тарилга, арьс салст цоолох ажилбар хийхдээ аюулгүй байдлыг хангаж ажиллах	2.1	“Заавар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 13 дугаар хавсралтаар баталсан “Тарилгын аюулгүй байдлын заавар”-ыг мөрдөж, ажилбарын үеийн халдвараас сэргийлэх үйл ажиллагааг хэвшүүлэх	- Ажилбар гүйцэтгэх орчинд тавигдах шаардлагыг хэрэгжүүлэх, хэвтэн эмчлүүлэх хэсгийн гарын эрүүл ахуй сахиx нөхцлийг сайжруулах - Ажилбарт хэрэглэх эмнэлгийн хэрэгслийн цэвэр, ариун нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, үжилгүйжүүлэх дэглэм, ажилбар гүйцэтгэх үйлдлийн стандартыг мөрдөж ажиллах - Ажилбарын явцад цус, биологийн шингэн, тарилгын уусмалаар тарианы тэргэнцэр, тавиур, тарилга бэлтгэх орчин бохирдох эрсдэлээс сэргийлж, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийх - Эрүүл мэндийн ажилтанг халдварт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангаж ажиллах
7	Мэс заслын дараахшархны халдвар илрүүлэх тандалт хийж, бүртгэж мэдээлдэг байх	5.1	“Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/-ыг тандах заавар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/539 тоот тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх	- ЭМС-ын 2019 оны А/539 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтын нийтлэг заавар”-ыг хэрэгжүүлж, мэс заслын тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид шархны халдварыг тандах, төрсний дараа эх, нярайд халдвар илрүүлэх тандалтыг тус тус хяналтын хуудсаар хийж, эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэн халдвараас сэргийлэх арга хэмжээ авах, бүртгэл судалгааг үндэслэн Эрүүл мэндийн газарт мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх - Уян зүү, шээлгүүр, амьсгалын гуурс тавих зэрэг эрсдэлтэй ажилбаруудыг гүйцэтгэх арга барилд гардан болон дагалдуулах сургалтыг зохион байгуулан дадлагажуулж, ажилбар хийх явцад халдвараас сэргийлэх

				дэглэмийн мөрдөлтөд үнэлгээ хийх, шалгуур хуудас ашиглан тандалт хийж, бүртгэл, судалгаатай ажиллах
8	Халдварт өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зохион байгуулалт хийдэг байх	6.2	Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5081:2013 стандартын 8.3.8 дах заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтаар баталсан “Тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээний заавар” -ыг мөрдөж ажиллах	- Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шаардлагатай үед халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлан эмчлэх - Халдварт өвчний дэгдэлтийн үед үйл ажиллагааны урсгалыг зохицуулахаар үзүүлэх сургууль зохион байгуулж, дайчлах схемийг боловсруулах, зураглал гаргах, дадлага, туршилтыг хийж, бэлэн байдлыг хангаж ажиллах - Эрүүл мэндийн байгууллагын орчин, ажиллагсад, бусад үйлчлүүлэгчид халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээг зохицуулах, халдвар дамжих замд суурилсан нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ДЭД БҮЛЭГ 1: ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ				
9	Тасаг, нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааны зохицуулалтыг хийсэн байх	2.2	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.5 дахь заалт, ЭМС-ын 2021 оны “Журам батлах тухай” А/813, А/814; ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаалыг хэрэгжүүлэх журмуудыг боловсруулахдаа Монгол улсын MNS:5140:1:2021, MNS 5140:2:2021, MNS 5140:3:2021-баримт бичгийн стандартыг мөрдөх	- СЭМТ-ийн амбулатори, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, лавлагаа шатлалын эмнэлэгтэй үйлчлүүлэгч шилжүүлэх, тээвэрлэх, бүртгэх, хянах, эргэн мэдээлэх тусламж үйлчилгээг зохицуулсан журам боловсруулж, даргын тушаалаар батлах - Эмнэлэгт хэрэглэж байгаа журам, тушаал зэрэг албан бичиг баримтыг дурдсан баримт бичгийн стандартын дагуу боловсруулж хийж хэвших, хүний нөөцийн ажилтанг сургах - Журмыг эмнэлгийн нийт албан хаагчдад танилцуулж баталгаажуулах - Журмын хэрэгжилтэнд хяналт тавьдаг, үнэлдэг байх
ДЭД БҮЛЭГ 2: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА				
10	“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлж, хянадаг байх	1.1	ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах заавар”-ыг хэрэгжүүлэх	- Холбогдох тушаалд заасны дагуу чанар, аюулгүй байдлыг сайжруулах 10 зорилттой төлөвлөгөөг боловсруулан төвийн дарга батлан, аймгийн ЭМГ-ын холбогдох ажилтнаар баталгаажуулна - Хагас жил, бүтэн жилд тайлан гаргах - СЭМТ-ийн даргаар томилсон баг нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнд жилд 2 удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийдэг байх - Төв нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөгөө Магадлан итгэмжлэлийн цахим системд жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор байршуулж баталгаажуулдаг байх - Төв нь чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Магадлан итгэмжлэлийн цахим системд байршуулдаг байх

11	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал /ЭМТҮЧАБ/-ын багийн үйл ажиллагаа тогтмолжсон, асуудалд чиглэсэн тодорхой, үр дүнтэй ажилладаг байх	1.2	МУ-ын Шадар сайд, ЭМС-ын хамтарсан 2019 оны 116/A565, 2019 оны A/566 /1,3 дугаар хавсралтаас бусад/, 2024 оны A/112 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх	- ЭМТҮЧАБ-ын багийн тушаалыг шинэчлэн гаргах, ажиллах журмыг холбогдох тушаалуудыг үндэслэн шинэчлэн боловрсруулж батлах - Чанар, аюулгүй байдлын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолт /АТТ/-д холбогдох тушаал, шийдвэрт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгаж баталсан байх - АТТ-д заасан чиг үүргийн дагуу ажиллуулдаг байх - Баг нь төлөвлөгөөтэй, хэрэгжүүлдэг, хянадаг тогтолцоотой, байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд жил бүр дүн шинжилгээ хийсэн, гарсан ахиц, үр дүн үр дүнг тооцдог байх
12	Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх	2.1	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.4.3; 6.4.4 дахь заалтыг хэрэгжүүлэх, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай” ЭМС-ын 2019 оны A/566 тушаалын 2, 4, 6 дугаар хавсралт, хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр дотоод хяналт тогтмол хийдэг байх	- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр дотоод хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөө, графиктай байх - Хяналт, үнэлгээнд хяналтын хуудсууд /ганц сувилахуй биш, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж заавар ашиглан эмнэлзүйн хяналт хийх хуудас боловсруулах/ ашигладаг байх - Хяналт, үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт, үр дүнтэй байх - Дотоод, хяналт үнэлгээний дүгнэлтэд үндэслэн ажил сайжруулах ажлын зөвлөмж, өгдөг, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байх - Дотоод хяналт, үнэлгээгээр илэрсэн асуудлыг удирдлагын зөвлөлд танилцуулдаг шийдвэрлэдэг байх - Ажил сажруулах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх, үйл ажиллагаа сайжирсан, үр дүн гарсан тайлантай байх
13	Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх.	2.2	Тусламж үйлчилгээний нэгж бүрт үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ тогтмол хийдэг байх	- СЭМТ-ийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл бүрээр чанар, аюулгүй байдлын өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан даргын тушаалаар батлах - Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр баталсан шалгуур үзүүлэлтийг тогтмол /сар, улирал, хагас, бүтэн жилээр/ хэмжиж, дүн шинжилгээ хийдэг, өмнөх жилүүдийн үзүүлэлттэй болон ижил төстэй үйл ажиллагаатай ЭМБ-ын үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт гаргадаг, тайлантай байх - Үр дүнг нийт ажилтнуудад танилцуулдаг байх, шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээ авдаг байх - Үндэсний болон олон улсын түвшинд мөрддөг үзүүлэлтүүдтэй харьцуулж, сайжруулах арга хэмжээ авч ажилладаг байх

14	Тусламж, үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх	4.2	ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтын дагуу тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх, ЭМС-ын 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” А/136 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 1.2.2 заалтыг хэрэгжүүлэх	- Холбогдох журам, зааврыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиолдол бүртгэх, хариу арга хэмжээ авах журмыг боловсруулан батлах - http://eburtgel.moh.gov.mn/ нэгдсэн мэдээллийн санд нэгдэх, эмнэлгийн хаягыг үүсгэж, зааврын дагуу тохиолдол, эрсдлийг бүртгэж мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх - Бүртгэгдсэн тохиолдол бүрт дүн шинжилгээ хийн, хэлэлцүүлэг хийдэг байх - Тохиолдлын мөрөөр арга хэмжээ авч, хэрэгжүүлдэг, зэмлэн буруушаахгүй, тохиолдлыг илрүүлж засах арга хэмжээ авч амжилттай ажилласан тасаг, нэгж, ажилтанг урамшуулдаг байх - Жил бүрийн тайлантай байх
15	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа зохион байгуулдаг байх	4.3	Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлдэг байх	- Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх журам боловсруулж батлах - Журмыг хэрэгжүүлдэг байх - Журмын хэрэгжилтэнд хяналт тавьдаг байх

ДЭД БҮЛЭГ 3: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

16	Ажилтан бүрийн албан тушаалын тодорхойлолтыг тусламж, үйлчилгээний өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, баталгаажуулсан байх	1.5	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.6.4 дэхь заалтыг хэрэгжүүлэх Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 тоот тогтоолын дагуу албан тушаалын тодорхойлолтыг ажилтан нэг бүрээр гаргах	- Ажилтан бүрийн ажлын байрны чиг үүргийн дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах - АТТ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажил үүргийг тусгасан, ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг бүрдүүлэх, сайжруулах талаар тусгасан байх
----	---	-----	---	---

ДЭД БҮЛЭГ 4: МЭДЭЭЛЭЛИЙН УДИРДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

17	Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд мэдээллийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг тусгасан, хэрэгжүүлдэг байх	1.1	“Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.3.3, 6.9.2 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг байх	- СЭТМ нь хөгжлийн төлөвлөгөөндөө иргэд болон холбогдох бусад байгууллагуудад мэдээлэл өгөх, авах чиглэлээр мэдээллийн удирдлагыг сайжруулах ажлыг төлөвлөдөг байх - Мэдээллийн удирдлагын баг байгуулах, журам батлаж, жил бүр төлөвлөгөө гарган ажиллах - Жилийн ажлын тайланг гаргаж, үр дүнг тооцож байх
18	Байгууллага нь гадаад сүлжээтэй (цахим хуудас, Facebook page гэх мэт), байнга баяжилт хийгддэг, ашигладаг	3.1	Байгууллагын цахим хуудас, нүүр номын хуудаст баяжилт хийж хөтлөх ажилтныг томилж, албан тушаалын тодорхойлолтонд ажил үүргийн чиглэлийг	- СЭМТ-ийн нүүр номын хуудсыг /page/ нээж, иргэд мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэх - Цахим хуудсанд баяжилт хийдэг ажилтанг томилгоожуулж, АТТ-д энэ чиг үүргийг заасан байх - Цахим хуудсанд эмнэлгийн үйл ажиллагаа, цагийн хуваарь,

	байх		заасан байх	яаралтай тусламжийн дуудлага авах утасны дугаар болон иргэдэд өгөх зөвлөгөө мэдээлэлийг тогтмол тавих
ДЭД БҮЛЭГ 5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЗАСВАР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ				
19	Байгууллага нь тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журамтай, мөрддөг, байх	1.1	Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам батлах тухай” А/344 тоот тушаалын 1, 2 дугаар хавсралтаар баталсан “Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам”-ыг мөрдөж, засвар үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж, бэлэн байдлыг хангадаг байх	- “Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх” гэрээний үлгэрчилсэн загварыг баримтлан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах - Шаардлагатай тоног төхөөрөмжид шалгалт тохируулгыг хийлгэсэн тохиолдолд акт үйлдэн, техник ашиглалтын паспортод тэмдэглүүлж, гарын үсэг зурж баталгаажуулсан байх - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн гэрээт ажилтан, инженерийн хийсэн ажлын гүйцэтгэлийг үнэлдэг журамтай, явцын хяналтыг ажилтанд танилцуулж баталгаажуулсан, хийсэн ажлын гүйцэтгэлийн нэгдсэн тайланг гаргаж, жилийн эцэст хэлэлцүүлдэг байх
20	Тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх	3.5	Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг зөв, зохистой байршуулах	- Ариутгалын болон сэргээн засах уламжлалт эмчилгээний аппарат хэрэгсэл, лабораторын тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллах нөхцлийг хангуулж, нэг тоног төхөөрөмжид ноогдох талбай, стандартад заасан хэмжээнд нийцүүлэн байршуулах - Өндөр даралтын ариутгалын тоног, төхөөрөмжийн аюулгүй байдал, ашиглалтын явцад инженерийн хяналт хийлгэх, засвар үйлчилгээ хийлгэсэн тэмдэглэлийг хөтлүүлэх, автоклавын манометрийг баталгаажуулах
БҮЛЭГ 3. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИ				
I.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
21	Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцсон байх	1.4	“Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 7.1.3, 7.3.2.1-7.3.2.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах	- Сумын хүн амын дунд зонхилон тохиолдох өвлөлийн судалгаатай болох - Үндэсний арга хэмжээ болон Төрөөс Нийгмийн эрүүл мэндийн талаар баримталж буй бодлоготой уялдуулан өөрийн сумын эрүүл мэндийн төвд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд /урьдчилан сэргийлэх үзлэг, ЭМБО сургалт, НЭМТҮ/ тусгаж ажиллах
22	Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа хийдэг байх	1.7	НЭМ-ийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3.1.6; 5.2.1; 5.10 дахь заалтууд, ЭМС-ын 2023 оны А/283 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.4 ЭМС-ын 2024 оны А/38 дугаар тушаалын	- Холбогдох эрх зүйн баримт бичгийг үндэслэн халдварт өвчний тандалт судалгааг тогтмол хийдэг байх - Эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох судалгааг хийн МСС хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллах, хяналт үнэлгээ хийн, үр дүнг тооцон ажилладаг байх - Шинэ болон шинээр сэргэн тархаж

			нэгдүгээр хавсралтын 4.6, А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.5, ЭМС-ын 2023 оны А/133 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7, ЭМС-ын 2022 оны А/577, ЭМ-ийн сайдын 2022 оны А/528 тоот тушаалыг мөрдөн ажиллах	байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, тайлан мэдээтэй ажиллах
23	Зүрхний архаг дутагдлын болон дислипидемийн эрт илрүүлэг хийдэг байх	6.6	ЭМС-ын 2018.10.18, “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай” А/420 дугаар тушаал, 2018.11.05 “Зүрхний архаг дутагдлын оношилгоо, эмчилгээний заавар батлах тухай А/442 тушаалыг хэрэгжүүлэн ажиллах	- Зүрхний архаг дутагдлын эрт илрүүлэх үзлэгт 35 ба түүнээс дээш насны хүн амыг жил бүр хамруулах Шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэлтэй болох

II. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИ

1.ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

24	Хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай байх, гэрийн эргэлт, хяналтыг тогтмол хийдэг байх	2.4	Хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай байх	- Тухайн жилд хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай байх Үзүүлсэн тусламж үйлчилгээг дүгнэдэг тайлагнадаг байх
25	Төрөлтийн явцад ариун материал хэрэглэдэг байх	5.6	ЭМС-ын 2019 оны 11-р сарын 29-ны өдрийн А/537 “Заавар батлах тухай” тушаалыг хэрэгжүүлж ажиллах	- Нэг удаагийн эх барихын цомогтой байгаа боловч нярайд зөвхөн нэг удаагийн эмнэлгийн хэрэгслийг хэрэглэх, нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах - Эх барихын тусламж, үйлчилгээний хүндрэлийг тооцож, тусламж, үйлчилгээнд шаардлагатай бүх багаж хэрэгслийг / багаж, зүү, утас, хайч/ бэлэн байдлыг хангаж ажиллах
26	Ая тухтай нөхцөлийг хангасан эхчүүдийн амрах байртай, үйлчлэх хүрээний эхчүүдийг амраасан хувь жил бүр нэмэгдсэн байх	7.1	“Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 6.10.2, 8.8.7 дах заалтыг хэрэгжүүлэх	- Амрах байранд байгаа жирэмсэн эхэд хяналт тавих журам боловсруулан баталгаажуулах - Журмын хэрэгжилтийг ханган ажиллах

2.ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

27	Тав хүртэлх насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналтыг удирдамж, зааврын дагуу хийдэг байх	2.3	ЭМС-н 2018 оны “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн эмнэлзүйн заавар батлах тухай” А/489, 2022 оны “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн	- Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийг эрэмбэлэн ангилалт эмнэлзүйн зааварын дагуу хийж тусламж үйлчилгээ үзүүлэн анхан шатны маягт хөтлөж хэвших - 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг тушаалын дагуу магадлан
----	---	-----	---	--

			эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” А/263, 2019 оны А/611, тушаалуудыг хэрэгжүүлэх	хэлэлцэж хэвших, тэмдэглэл хөтлөх бүртгэлтэй болох - Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан тусламжийг үзүүлж, эндэгдэлд хүргэж байгаа шалтгаан үр дагаврын судалгаанд үндэслэн, хариу арга хэмжээг мэргэжлийн байгууллгын түвшинд хамтарсан багаар хэлэлцэн шийдвэрлэдэг, үр дүнг тооцдог болох; - Хүүхдийн эрэмбэлэн ангилал, яаралтай тусламжийн стандарт, ХӨЦМ-ийн үнэлгээ, зөвлөгөө өгөх орчныг бий болгох, эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг сайжруулах сургалтын чанар, үр дүнг нэмэгдүүлэх - Хүүхдийн хорт хавдарын ТҮ-г тушаалын дагуу бүртгэл хяналтыг сайжруулан ажиллах - АШМ-г үнэн зөв хөтлөж ,мэдээг нэгтгэн зөв мэдээлэл гаргах, мэдээ тайланд дүгнэлт хийн үр дүнг тооцож хэвших - Тушаалуудын хэрэгжилтэнд дүгнэлт хийж үр дүнг тооцох - Тушаал шийдвэрийг ЭМА-дад танилцуулан мэдлэг мэдээлэлтэй болгох
28	Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг удирдамж зааврын дагуу хийдэг, зөвлөгөө өгдөг байх	2.4	Эрүүл мэндийн сайдын 2024-12-12 өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дугаар тушаалын 1.1,1.3,3.1,5.1-5.13,6.6.1,6.6.2,6.6.3, гуравдугаар хавсралт заалт бүрийг хэрэгжүүлэх	- Үйлчлэх хүрээний өсвөр үеийнхний бүртгэл судалгааг жил бүр шинэчилж, эрүүл мэндийн бүлэгт ангилан, өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг хяналтанд авч ажиллах - Өсвөр үеийнхнийг дархлаажуулах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх ажлыг дангаар болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах - Өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах
3.МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
29	Мэс заслын дараа шарх халдварлахаас сэргийлдэг байх	5.2	Мэс заслын /эх баригч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн/ гар угаалтанд хлоргексидин, повидиниод, пара-хлор-мета-гексинол болон триклосон агуулсан уусмал, губкаг 1 удаагаар хэрэглэдэг байх	- Мэс засал, төрөхийн тусламж үзүүлэхэд эмнэлгийн мэргэжилтэн гар угаалтанд хлоргексидин, повидиниод, пара-хлор-мета-гексинол болон триклосон агуулсан уусмалтай губкаг 1 удаагаар хэрэглэдэг байх - Гар угаах губканы нөөцийг бий болгох, жил бүр тодорхой хэмжээгээр захиалан бэлэн байдлыг хангадаг байх

30	Мэс заслын өрөөг камержуулсан байх	6.4	ЭМС-ын 2013 оны “Журам батлах тухай” А/178 дугаар тушаалын хавсралт “Мэс заслын камерын системийг ажиллуулах журам” -ыг хэрэгжүүлэх	- Хагалгааны өрөөнд камер тавих - Хяналтын дэлгэцийг СЭМТ-ийн даргын өрөөнд байрлуулах - Хянадаг байх
4.МЭДЭЭГҮЙЖҮҮЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
31	Мэдээгүйжүүлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журамтай, хэрэгжүүлдэг байх	1.1	Ерөнхий журам батлах, тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангах	- Яаралтай тохиолдолд АНЭ-с ирэх мэдээгүйжүүлгийн багийн ажиллах нөхцөлийг хангах /өрөө бэлтгэх, өөртөө байх яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, мэдээгүйжүүлэгт хэрэглэх АШМ-ууд, мэс заслын дараах 2 цагийн хяналт хийх гэх мэт зүйлүүдийг тусгасан/, хариуцсан ажилтны үүргийг тусгасан журам боловсруулан батлах, хэрэгжүүлэх - Өөрийн эмнэлэгт хэсгийн мэдээгүйжүүлэг хийхэд шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гаргаж бэлэн байдлыг хангадаг, өдөр тутмын бэлэн байдлыг хянадаг байх
9.СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
32	Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийг хийх эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг үнэлдэг, сургадаг байх	2.6	“Эрүүл мэндийн технологи, Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд MNS 4621: 2008 стандарт”, ЭМХТ-ийн захирлын 2023.08.18, А/69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг ашиглах гарын авлага” 4.2, 7, 8, 9--р хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	- Сумын ЭМТ-ийн үзүүлж буй сувилахуйн тусламж үйлчилгээний хүрээнд гардан үйлдлийн ур чадварыг үнэлэх журам боловсруулж, ЭМТ-ийн даргын тушаалаар баталгаажуулж, хэрэгжүүлэх - “Сувилагч мэргэжилтний ур чадварыг үнэлэх хуудас”-г сумын ЭМТ-ийн онцлогт нийцүүлэн, удирдамж, зааврын дагуу боловсруулж, батлуулан мөрдөх - Сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамж, зааврын хэрэгжилтийг шалгуур хуудсын тусламжтай үнэлж дүгнэх, сайжруулах ажлыг хийдэг, сургадаг байх
10.ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
33	Эрчимт эмчилгээний нэгжид эмчлэх эмнэл зүйн заалтыг тодорхойлсон, баталсан журамтай мөрддөг байх	1.5	Сум тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS5081:2013 стандартын 8.14.4 заалтыг хэрэгжүүлэх	- Эрчимт эмчилгээний өрөөнд эмчлэгдэх заалт, эрчимт эмчилгээний өрөөнөөс энгийн өрөөнд шилжүүлэх эмнэл зүйн заалтыг гаргах - Шаардлагатай тохиолдолд цахим технологи ашиглан зайн оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авах боломж нөхцлөөр хангах
11.ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ				
34	Түргэн тусламжийн автомашиныг тусламж, үйлчилгээ үзүүлэхээр тоноглож байх	1.3	Эрүүл мэндийн сайдын 2023оны 6-р сарын 22 өдрийн” Журам батлах тухай “А/ 220 дугаар тушаалын 5.1.1 - 5.1.8,5.2.6.1,8.1,8.3,8.4,8.5.1 заалт; Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6717;.,2018	- Хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх - Насильк дээр дэвсэх гудас, хучих хучлагийг хэрэглэсэн тохиолдол бүрт угаалга цэвэрлэгээнд өгч халдвар хамгааллыг сахин ажиллах - Үйлчлүүлэгчийг хянах төхөөрөмжийг байрлуулах - Жагсаалтын дагуу эмнэлгийн хэрэгслүүдийг төрөл бүрээр

			стандартын В хавсралт, Сум тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5081:2013 стандартын 8.14.7 заалтуудыг тус тус хэрэгжүүлэх	ньтөрөлжүүлэн хэмжээ тус бүрээр нь бэлдэх, бэлэн байдалд үнэлгээ хийдэг байх - Жолоочид биологийн шингэн цэвэрлэх заавраар сургалт хийдэг, гүйцэтгэлийг хянадаг байх
12.ЭМИЙН МЕНЕЖМЕНТ БА ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ				
35	Нянгийн тэсвэржилтээс сэргийлж антибиотикийн хэрэглээг багасгах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээ авсан байх	3.1	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2025-2-13 өдрийн “Эмийн эмчилгээний хороо болон бичилт биетийн эсрэг эмийн дэд хорооны ажиллах журмыг шинэчлэн батлах тухай “А/28 дугаар тушаалын 1.5, 4.1.11 заалтыг хэрэгжүүлэх	- СЭМТ-д хэрэглэж буй нянгийн эсрэг эмийн хэрэглээг үнэлэх - Хязгаартай хэрэглэх антибиотикийн жагсаалтыг гаргах, нөөцийн бүрдүүлэлт хийх - Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулдаг байх
36	Гамшиг, онцгой байдлын үед хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцтэй, хэрэглээ,хадгалалт, зарцуулалтыг тооцдог байх	5.2	ЭМС-ын 2023 оны А/211 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Эрүүл мэндийн байгууллагат байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалт” -ын дагуу өөрийн эмнэлэгт байх нөөцийн жагсаалт гарган, бэлэн байдлыг хангах	- Онцгой байдлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн жагсаалт гаргаж эмнэлгийн захирлаар батлуулах - Нөөцийг бий болгож, зохих стандартын дагуу хадгалах, зарцуулах - Нөөцийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад нөөцийн байдалд хяналт хийдэг, үр дүнг тооцдог байх
13.ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ				
37	Шинжилгээний дотоод хяналтыг тогтмол хийдэг, гадаад хяналтанд хамрагдсан байх	3.1	“Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5081:2013 стандартын 8.4.4, 8.4.5 заалтыг мөрдөн ажиллах	- Сумын ЭМТ-д хийж буй шинжилгээний нэр төрөл бүрээр чанарын дотоод үнэлгээг хийж, дүгнэх - Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторийн тасагтай хамтран ажиллаж, шинжилгээний чанар, хяналтыг сайжруулах - Хийж буй шинжилгээний нэр төрөл бүрээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдах

Шинжээчдийн баг:

Ахлагч: Т.Наранзул

Гишүүд: З.Оюунханд

Д.Самбуудорж

В.Адъяажав

Хянасан: С.Мөнхсүх /ТҮЧМИА-ны мэргэжилтэн/